БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ
АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛЬ

ВУЙПЭЛЖИНГИЙН ГО-ВА

# ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН СУДЛАГАА

Е 09120122 - Сэтгэцийн эмгэг судлал

Анагаах Ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт зохиолын хураангуй

Улаанбаатар хот
2017 он

## УДИРТГАЛ

### 1. Судлагааны ажлын үндэслэл

ДЭМБ-аас гаргасан насны ангилалаар 0-9 насыг хүүхэд нас, 10-19 насыг өсвөр нас хэмээн үздэг[1] бол судлаач Б. Оргилын “Монгол хүний насны ангилал”-аар 0-11 насыг хүүхэд насны үе, 12- 20 насыг өсвөр насны үе гэж ангилжээ.[2]

Монгол улсын Иргэний хуулинд зааснаар (15.1) иргэний эрхзүйн бүрэн чадамж нь 18 наснаас бий болдог тул хүүхэд, өсвөр насныханд насанд хүрэгчдийн асран хамгаалал зайлшгүй шаардлагатай байдаг.[3]

НҮБ-аас батлан гаргасан Хүүхдийн эрхийн конвенцид зааснаар “ Хүүхэд хамгааллын асуудал нь төрийн үүрэг бөгөөд << хүүхэд хамгаалал >> гэдэг нь хүүхдэд хохирол учруулж буй аливаа хортой үйлдэл болон үйл ажиллагаа, бэлгийн мөлжлөг, дарамт, хүчирхийллээс хамгаалахыг хэлнэ” гэжээ. Түүнчлэн 18 нас хүрээгүй хүн бүрийг “хүүхэд” гэнэ хэмээн тодотгон заасан байна.[4]

Гэтэл НҮБ болон бусад олон улсын байгууллага, хүүхэд хамгааллын салбарын ажилтнууд нь хүүхэд бие бялдар, сэтгэл зүй, насны онцлогоосоо хамааран дарамт, хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах явдлын золиос болж байна гэж үзэж байна.[5] Хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь дэлхийн олон улс оронд нийтлэг тулгамдсан асуудал болсныг харгалзан НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын санаачлагаар 2007 оноос эхлэн жил бүрийн 10-р сарын 19-нийг “Хүүхдийн хүчирхийллийн эсрэг олон улсын өдөр” болгон тэмдэглэхээр зарлажээ.[6]

Дэлхийн бараг бүх улс оронд эцгийн эрхт ёс ноёрхож байгаатай холбоотой хүчирхийлэл, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг, гэр бүлийн доторх хүчирхийлэл нийгмийн дунд оршсоор байна.[7]

НҮБ-ын Хүүхдийн Сангаас (2001) Европ, Төв Азийн 35 орны хүүхдийн дунд хийсэн судлагаагаар дунджаар 10 хүүхдийн 6 нь өөрийн гэр бүлдээ ямар нэг хэлбэрийн хүчирхийлэлд өртдөг ажээ.[8]

ДЭМБ-аас насанд хүрэгчдийн дунд хийсэн судлагаагаар эмэгтэйчүүдийн 20%, эрэгтэйчүүдийн 5-10% нь хүүхэд насандаа бэлгийн хүчирхийлэлд, 25-50% нь биемахбодын хүчирхийлэлд өртдөг гэсэн үр дүн гарчээ.[9]

Олон улсын байгууллагын судлагаагаар хүүхдийн эсрэг хүчирхийллийн ихэнхийг сэтгэцийн хувьд эрүүл хүмүүс үйлддэг гэсэн мэдээлэл байгаа боловч

сүүлийн жилүүдэд хүүхдийн амийг онц ноцтой, хэрцгий аргаар егүүтгэсэн сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн тухай мэдээлэл олон нийтийн сэтгэлийг сэртхийлгэж байгаа билээ.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь Монгол улсын хувьд ч тулгамдсан асуудлын нэг болж ялангуяа бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртөж буй хүүхдийн тоо нэмэгдэж байна гэдгийг олон байгууллага хүлээн зөвшөөрч байна.[10]

Монгол улсад хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх судлагааг гэр бүл, сургуульд түшиглэн 1998, 1999, 2001, 2005, 2014 онуудад хийж судлагааны үр дүнд хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүдийг судлан тогтоосон байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн улмаас хүүхдийн биемахбод, сэтгэлзүйн гэмтэл, бие даасан сэтгэцийн эмгэг үүсэх, амийг егүүтгэх зэрэг сөрөг үр дагавар гарах бөгөөд аль ч хүчирхийллийн үед сэтгэлзүйн гэмтлийн дараах стрессийн эмгэг үүсдэг онцлогтой.

Монгол улсад хүүхдийн хүчирхийлэлтэй холбоотой сэдвээр судлаач Н.Дэмидмаа “Архинд донтох эмгэгтэй хүмүүсийн хүүхдийн сэтгэцийн эрүүл мэнд” (2001), Б.Жаргал “ Хүүхдийн сэтгэлзүйн гэмтлийн дараах стрессийн эмгэг” (2006), Б.Пүрэвжаргал “Гэр бүлийн хүчирхийлэл сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлөх нь” (2007), Н.Алтанзул “Хүчирхийлэлд өртсөн өсвөр насны хүүхдийн сэтгэл түгшилтийн байдлыг харьцуулан судласан нь” (2013) зэрэг судлагаа хийж Анагаах ухааны докторын болон магистрын зэрэг хамгаалсан байдаг.

Одоогоор Монгол улсад хүүхдийн эсрэг хүчирхийллийг Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын асуудал, сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн үйлдсэн нийгэмд аюултай үйлдэл, сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн хүүхэд хамгааллын асуудалтай холбон судласан судлагаа байхгүй байгаа тул бид энэхүү сэдвийг сонгон судлахыг зорьсон юм.

## 2. Судлагааны ажлын зорилго

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүд, нөлөөлөх зарим хүчин зүйлсийг судлан тогтооход оршино.

## 3. Судлагааны ажлын зорилт

1. СЭМҮТ-ийн Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын магадлан шинжилгээнд хамрагдагсдын баримтанд судлагаа хийж хүүхэд хүчирхийлэлд өртсөн байдал, хүчирхийллийн хэлбэрүүдийг судлан тогтоох

2. Сэтгэцийн эмгэгийн улмаас хүүхдэд аюултай үйлдэл хийсэн өвчтөнүүдийн сэтгэц эмгэгийн онош, хамшинж, үйлдлийн хэлбэрийг судлан тогтоох
3. Хүүхэд хүчирхийлэлд өртөхөд нөлөөлж буй зарим хүчин зүйлсийг судлан тогтоох

## 4. Судлагааны ажлын шинэлэг тал

Судлагааны шинэлэг тал нь СЭМҮТ-ийн архивын баримтанд эргэмж судалгаа хийж хүүхэд зонхилон өртөж буй хүчирхийлэл, нийгэмд аюултай үйлдлийн хэлбэрүүд, түүнд нөлөөлөх хүчин зүйлс, сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн хүүхдийн асран хамгааллын асуудлыг дэвшүүлэн тавьсанд оршино.

## 5. Судлагааны ажлын практик ач холбогдол

1. Хүүхэд хүчирхийлэлд өртөх шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсийг судлан тогтоосноор хүчирхийлллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах
2. Хүүхдийн эсрэг нийгэмд аюултай үйлдэл хийхэд хүргэдэг сэтгэцийн эмгэг, хамшинжийг судлан тогтоосноор сэтгэцийн эмгэгийг эрт илрүүлэн оношлох, эмчлэх, нийгэмд аюултай үйлдэл хийхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах

## 6. Хамгаалахаар дэвшүүлж буй асуудлууд

1. Хүүхэд хүчирхийлэлд өртөх тохиолдол их байна
2. Хүүхэд хүчирхийлэлд өртөхөд нөлөөлөх хүчин зүйлс олон байдаг
3. Сэтгэцийн эмгэгтэй хүмүүс хүүхдэд аюултай үйлдэл хийдэг

## 7. Судлагааны ажлын ёс зүй

1. Судлагааг СЭМҮТ-ийн архивын бичиг баримтанд тулгуурлан хийж буй учир СЭМҮТ-ийн ерөнхий захирал, АУ-ны доктор, дэд профессор Л.Насанцэнгэлд судлагааны ажлын арга, аргачлал, ёс зүйн асуудлыг танилцуулж (2015.10.28-өдрийн 2/189 тоот) судлагааны ажил хийх зөвшөөрөл албан бичгээр авсан. Мөн сэтгэцийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгсдээс эмнэлзүйн ярилцлага хийх зөвшөөрөл авсан болно.

2. Судлагааны арга зүйг АШУҮИС-ийн Судалгааны Ёс Зүйн Хяналтын Хорооны 2016 оны 01-р сарын 15-ны хурлаар (хурлын шийдвэр № 6/3/2016-06) хэлэлцүүлж баримтын болон эмнэлзүйн ярилцлага хийх зөвшөөрөл авсан.
3. Судлагааны ажлыг хийж дууссаны дараа СЭМҮТ-ийн ерөнхий захирал, эмнэлэг эрхэлсэн орлогч дарга нарт судалгааны ажлаа танилцуулж, хэлэлцүүлэн судлагааны ажлын явцад ёс зүйн зөрчил гаргаагүй хэмээсэн дүгнэлт гарсан. (2016.03.24-ний өдрийн 2/82 тоот)
4. Судлагааны ажлын үр дүнг АШУҮИС-ийн Судлагааны Ёс Зүйн Хяналтын Хорооны 2016 оны 05-р сарын 06-ны өдрийн хурлаар (хурлын шийдвэр 13/Д/2016-13) хэлэлцүүлж ёс зүй зөрчөөгүй гэсэн дүгнэлт гарсан.

## 8. Судлагааны ажлын бүтэц хэмжээ

Магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл нь удиртгал, хэвлэлийн тойм, судлагааны материал ба аргазүй, судлагааны үр дүн, хэлцэмж, дүгнэлт, практик зөвлөмж гэсэн 4 бүлэг, ном зүй, талархал, хавсралт гэсэн бүтэцтэй, А4 хэмжээтэй, Arial фонтыг ашиглан 72 хуудсанд багтаан бичив.

## 9. Судлагааны ажлын үр дүнг хэлэлцүүлсэн байдал

1. АШУҮИС-ийн Сэтгэцийн Эрүүл Мэндийн Тэнхим, СЭМҮТ-ийн Эрдмийн зөвлөлийн хамтарсан (2015 оны 12-р сарын
2. 04–ний өдрийн) хурлаар судлагааны ажлын сэдэв, аргачлалыг хэлэлцүүлэн батлуулсан (протокол 24/15)
3. АШУҮИС-ийн Сэтгэцийн Эрүүл Мэндийн Тэнхим, СЭМҮТ-ийн Эрдмийн зөвлөлийн хамтарсан (2016 оны 04-р сарын 16–ний өдрийн) хурлаар судлагааны ажлын явцыг хэлэлцүүлсэн (протокол 02/16)
4. АУС-ийн Сэтгэцийн эрүүл мэндийн тэнхимийн өргөтгөсөн хурлаар (2016 оны 06-р сарын 28) урьдчилсан хамгаалалтын хэлэлцүүлэгт орж дахин хэлэлцүүлэх шийдвэр гарсан (протокол 17/16) .
5. АУС-ийн Сэтгэцийн эрүүл мэндийн тэнхимийн өргөтгөсөн хурлаар (2016 оны 12-р сарын 01) урьдчилсан хамгаалалтын хэлэлцүүлэгт орж жинхэнэ хамгаалалтанд оруулах шийдвэр гарсан (протокол 23/16).

## 10. Судлагааны ажлын үр дүнг хэвлүүлсэн байдал

**Эрдэм шинжилгээний өгүүлэл:**

1. В.Го-Ва, Э.Минжмаа, Д.Лянхуа, Д.Оюунсүрэн, З.Хишигсүрэн. Сэтгэцийн эмгэгийн улмаас нийгэмд аюултай хүүхдийн эсрэг үйлдэл хийсэн

**ГАРЧИГ**

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ 5

ЗУРГИЙН ЖАГСААЛТ 6

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ 7

ЭМНЭЛЗҮЙН ТОХИОЛДЛЫН ЖАГСААЛТ 8

**УДИРТГАЛ** 9

1. Судлагааны ажлын үндэслэл 9
2. Судлагааны зорилго 10
3. Судлагааны зорилтууд 10
4. Судлагааны ажлын шинэлэг тал 10
5. Судлагааны ажлын практик ач холбогдол 11
6. Хамгаалахаар дэвшүүлж буй асуудал 11
7. Судлагааны ажлын ёс зүй 11
8. Нэг сэдэвт бүтээлийн бүтэц, хэмжээ 11
9. Судлагааны үр дүнг хэлэлцүүлсэн байдал 12
10. Судлагааны ажлын үр дүнг хэвлүүлсэн байдал 12

**БҮЛЭГ 1. ХЭВЛЭЛИЙН ТОЙМ**


1.1 Хүүхэд хамгаалал, хүүхдийн эсрэг хүчирхийллийн тухай ерөнхий ойлголт 13

1.2 Хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүд, тархалт 15

1.3 Хүүхэд хүчирхийлэлд өртөх шалтгаан, нөлөөлөх зарим хүчин зүйлс 22

1.4 Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл 25

1.5 Сэтгэцийн эмгэг ба хүүхдийн эсрэг нийгэмд аюултай үйлдэл 29

1.6 Хүүхдийн эсрэг хүчирхийллийн үр дагавар 32


**БҮЛЭГ 2. СУДЛАГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, АРГА ЗҮЙ**


2.1. Судлагааны үе шат 35

2.2 Судлагааны загвар 35

2.3 Судлагааны ажлын загвар, хамрах хүрээ, түүвэрлэлт 36

2.4 Судлагааны ажлын мэдээ, материал цуглуулсан аргууд 36

2.5 Судлагаанд хамрагдагсдыг сонгох, хасах шалгуур 38

2.6 Судлагааны үр дүнгийн статистик боловсруулалт 38


**БҮЛЭГ 3. СУДЛАГААНЫ ҮР ДҮН**


3.1 Хүүхэд хүчирхийлэлд өртсөн байдлыг судласан дүн 39

3.2 Сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн үйлдсэн нийгэмд аюултай үйлдэлд хүүхэд өртсөн байдал 53

**БҮЛЭГ 4. СУДЛАГААНЫ АЖЛЫН ХЭЛЦЭМЖ** 59
**СУДЛАГААНЫ АЖЛЫН ДҮНЭЛТ** 73
**ПРАКТИК ЗӨВЛӨМЖ** 74
**НОМ ЗҮЙ**
**ХАВСРАЛТ**

## НОМ ЗҮЙ


1. С.Бямбасүрэн. Гэр бүлийн доторхи хүчирхийлэлд өртсөн хохирогч нарт үзүүлэх нийгэм сэтгэлзүйн тусламж үйлчилгээ, эмчилгээ. “Гэр бүл хүчирхийлэл” бага хурал. УБ. 2001. х-35-37
2. Б.Оргил. “Монгол хүний насны ангилал”. Настанд үзүүлэх тусламж үйлчилгээ. УБ. 2009. х 51
3. Н.Орёл, Г.Доржханд, Х.Хулан. Шүүхийн сэтгэц гэм судлалын хичээлийн материалууд. УБ.2006. х-69
4. EndyBest. Save the children. Монгол улс дахь хүүхэд хамгааллын тогтолцоо. Судалгааны тайлан. УБ. 2006. х -49
5. Htpp\\www.child.or.gov.mn. Байгууллагын хүүхэд хамгааллын бодлого. Хүүхэд, гэр бүлтэй ажилладаг байгууллагад зориулав. УБ. 2014
6. www. News. Niigem.mn.content. 23922.
7. Д.Одонтуяа. Монголд гэр бүлийн хүчирхийллийн талаар асуумж авч судалсан байдал. Онош. 2002. №1 (013). х 1-4
8. Http:\www.Info@endcorporalpunishment.org. “ Хүнийг цохих буруу- хүүхэд ч гэсэн хүн шүү дээ”. 2011
9. WHO. Child maltreatment. www. who.int/mediacentre. 2010
10. Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв. Бэлгийн мөлжлөгийн хохирогч хүүхдэд хамтарсан багаар үйлчилгээ үзүүлэх арга зүйн туршилт. УБ. 2010.
11. И.Тэгшээхүү. Хүүхэд хамгааллын асуудал нийгмийн тулгамдсан асуудал болох нь. www. Tenger.edu.mn
12. Tracie O. Afifi, Harriet L. MacMillan, Michael Boyle, Tamara Taillieu. Child abuse and mental disorders in Canada. CMAJ, June 10, 2014, 186(9)
13. Хүний эрхийг хамгаалагчид байгууллага. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн тухай, хүний эрхийн тайлан. УБ.2014
14. Ц.Цолмон, Д. Бадамдорж. Өрх доторх хүүхэд хамгаалал. Ураг төрлийн хүчин. (Илтгэлийн уралдаанд 3-р байр эзэлсэн илтгэл) www.sochialwork.mn.Apr. 2010.
15. Д.Одонтуяа. Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрүүд, буруу ойлголт. “Гэр бүл хүчирхийлэл” бага хурал. УБ. 2001. х-1
16. Child abuse and neglect by parents and other caregivers. Chapter 3. www.who.int\violence-injury. 2000
17. Xiangming Fang, Deborah A Fry, Jinggi Chen. The burden of child maltreatment in Ching: a systematic review. Bulletin of the World Health Organization 2015;93:176-185.
18. Эрүүл мэндийн хөгжлийн төв. Эрүүл мэндийн үзүүлэлт -2014. УБ. 71
19. “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” Монгол улсын хууль. УБ.2003
20. М.Отгон. Монгол улс дахь хүчирхийлэл ба эрүүл мэндийн тухай илтгэл. УБ. 2006
21. Ж.Алтанцэцэг, Т.Цогзолмаа. Эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэж буй хүчирхийллийн хэлбэрүүд, өнөөгийн байдал. Хүчирхийллийн эсрэг төв. УБ. 2002

22. ДЭМБ, НҮБ-ын хүн амын сан, ЭМЯ. Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөгсдөд үзүүлэх тусламж үйлчилгээ. УБ. 2010. х-7
23. Child abuse and Mental health. Commonwealth of Australia 2005.
24. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль. УБ. 2014
25. Catherine So-kum, Tang A. The rate of physical child abuse in Chinese families. Abuse & Neglect. Volume 22,Issue 5, May 1998; 381-391. Original articles.
26. Dao-Ho Kim, Yong –Chon Park, Liang Dong Zhang. Children s experience of violence in China and Korea; a transcultural study. Presented at the World Congress of psychiatry, Hamburg, August 1999
27. Хүүхдийн хүчирхийллийн судалгаа. Http:\www. Childprotection .com.УБ. 2012
28. Хүүхдийг ивээх сан. Зохистой хөгжлийн жендер төв. “Хүүхдийн биемахбод, сэтгэл санааны эсрэг шийтгэл: Хүүхдийн үзэл бодол”. Хүүхдэд үйлчилдэг зарим байгууллагад хийсэн судалгааны дүнгийн товч тайлан. УБ. 2005.
29. Mongolian marketing consulting group. Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар. Хүүхдийн хүчирхийлэлд өртөж буй байдлын судалгаа-2014. УБ. 2014
30. Crime and misconduct commission. Vulnerable victims: child homicide by parents. Research and issues Paper. Number 10. June 2013.
31. Alexandre Martins Valenca, Antonia EgidioNardi, Isabella Nascimenta. Schizophrenia and violent behavior. Rev.Latinoam.Psicopat.Fund., San Paulo.v 14,n.4,p 660-671.Dezembro 2011.
32. Amy Orsborne, Sam Atkinson, Sarah Tomley et.al. The psychology book. UK.2012
33. Л. Төрбурам. Сэтгэл судлалын түүхийн жимээр. УБ. 2013.х 286
34. В.Г. Крыско. Нийгмийн сэтгэл судлал. (Л.Уранцэцэгийн орчуулга). УБ.2006. х-79, 93
35. Н.Ариун туяа, Х.Гэрэлсүрэн. Сэтгэлзүйн зөвлөгөөний үндэс. УБ.2007. х-13
36. Blace A, Nalavani, Scott D.Rayan. Childhood sexual abuse and the impact on postadoptive child and family functioning. Journal of child adolescent Trauma 1:119-134, 2008
37. Health & Parenting. What is Attachment Parenting.www.webd.com\ parenting 2014.
38. Natural parenting. ru.wikipedia.org. 2011
39. О.Мягмар. Сэтгэц заслын зөвлөгөөний арга зүй. УБ.2009. х 42
40. Jon Foster. Alcohol, domestic abuse and sexual assault. Institute of Alcohol studies. 2014
41. WHO. Centre for Public Health. Child maltreatment and alcohol. 2006.
42. Australian Primary Schools Mental health initiative. Mental health risk and protective factors. 2014
43. AfifiTO, Boman J, Fleisher W, Sareen J. The relationship between child abuse, parentaldivorse, and lifetime mental disorders and suicidality in a nationally representative adult sample. Epub 2009, Mar; 33 (3)139-47

44. Neil B. Guterman, Yookyong Lee, Shawna J Lee, Jane Waldfogel, Paul J. Rathouz. Fathers and maternal risk for physical abuse. Child maltreat. 2009. August; 14 (3):277-290
45. “Монгол улсын гэр бүлийн тухай хууль”. УБ. 2002
46. UNFPA Mongolia. Statement of the executive director, UNFPA. Сэтгэцийн эрүүл мэнд бид бүгдэд хамааралтай. Htpp:\country office. Unfa.org\ Mongolia. (НҮБ-ын хүн амын сангийн гүйцэтгэх захирлын илгээлт )2014
47. Ludovica Laccino. Child sexual abuse: Top 5 countries with the highest rates. www.ibtimes.co.uk\child -sexual abuse
48. Wenjing Zhang, JingQi Chen, Fengfeng Liu. Preventing Child Sexual abuse early: Preschool teachers knowledge, attitudes, and their education in China.SAGE open January- March 2015:1-8
49. JingQi Chen, Michael P.Dunne, Ping Han. Child sexual abuse in province China: associations with sadness, suicidality, and risk behaviors among adolescent girl. Journal of Adolescent Health. Volume 38.Issue 5, May 2006, 544-549
50. Kristine T. Futa, Eugenia Hsu, David J. Hansen. Child sexual abuse in Asian American families . Faculty Publications Department of psychology. Paper 101; 2001
51. WPRO. Mental health. Key facts. 2015
52. The Mental health of adolescent -2008. National Adolescent Health Information Center.
53. Xiangming Fang, Deborah A Fry, Jinggi Chen. The burden of child maltreatment in Ching: a systematic review. Bulletin of the World Health Organization 2015;93:176-185.
54. American academy of child adolescent psychiatry. Fact for families. Children of parents with mental illness. № 29. Washington. 2012
55. Parents with Mental Health Problems. Http:\www.taktent.org.uk/mental health articles. UK. 2013
56. American academy of child adolescent psychiatry. Fact for families. Children of parents with mental illness. № 39. Washington. 2008
57. Janice Wood. Mental illness prevalent in parents Who kill their children. http\psychcentral.com\news\2013\mental-illness-prevalent-in- parents.
58. Kirsten J Hancock, Francis Mitrou, Megan Shipley, David Lawersecne, Stephen Zubrick. A three generation study of the mental health relationships between grandparents, parents and children. BMC Psychiatry 2013, 13:299
59. Joanne Nicolson, Kathleen Biebel, Betsy Hinden, Alexis Henry, Lawrence Stier. Critical issues for parents with mental illness and their families. University of Massachusetts Medical school. July 30, 2001.
60. Leone Huntsman. Centre for parenting & Research. Parents with mental issues: Consequences for children and effectiveness of interventions designed to assist children and their families. November 2008.
61. Martin Erb, Roland Freese. Homicide and schizophrenia: maybe treatment does have a preventive effect. Criminal Behaviour and Mental health. Volume 11. Issue1. 6-26. March 2001

62. Dominigue Bourget, Alian Labelle, Pierre Gadne. First episode psychosis and homicide. Canadian Psychiatric Association. 2003
63. S. Hodgins, R Muller-Isberner. Preventing crime by people with schizophrenic disorders: the role of psychiatric services. BJP 2004, 185: 245-250
64. Elizabet Walsh, Alec Buchanan, Thomas Fany. Violence and schizophrenia: examining the evidence. BJP. 2002, 180:490-495
65. Jenny Mouzos, Catherine Rushforth. Family Homicide in Australia. Australian institute of criminology. № 255. June. 2003
66. Rasmussen K, Levander S. Schizophrenia and violence. Tidsskr Nor Laegeforen (Norwegia); 2002Sep 30:122(23):2303-5
67. Д.Лянхуа, Т.Ганцэцэг Сэтгэцийн өвчний улмаас гэмт хэрэг үйлдсэн эмэгтэйчүүдийн хэргийн онцлог. Сэтгэцийн эмгэгийн клиникийн эмнэл үүсэн байгуулагдсаны 75 жилийн ойн онол практкийн бага хурал. УБ. 2004.х- 100-107
68. “Сэтгэцийн эрүүл мэндийн тухай” Монгол улсын хууль. УБ. 2013
69. P.SusanPenfold. Children living with partner violence. CPA Bulletin September 2004. 36[4]: 10-12
70. Annamarie C. Hulette, Jennifer J.Freyd, KaterineC.Pears. Dissocation and posttraumatic symptoms in maltreated preschool children. Journal of child adolescent Trauma 1:93-108, 2008
71. Jeffery N, Wherry, Ariel S.Marrs. Anxious school refusers and symptoms of PTSD in abused children. Journal of child adolescent Trauma 1:109-117, 2008
72. Б.Жаргал . Хүүхдийн сэтгэлзүйн гэмтлийн дараах стрессийн эмгэг. АУ-ны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. УБ.2005.х- 6-9
73. Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв. Бэлгийн мөлжлөгийн хохирогч хүүхдийн эрхзүйн хамгаалалтыг сайжруулах нь. УБ. 2010.
74. Laura P Chen, M. Hassan Murad, Molly LParaset all. Sexual abuse and lifetime diagnosis of psychiatric disorders; Systematic Review and meta-analysis. Online original article. July 2010;85 (7):618-629
75. Б.Гомбосүрэн. Ёс зүй . УБ. 2008. х- 116-117
76. Х.Ноорман Враит (Б.Баянбилэгийн орчуулга). Аавын охин байхсан. УБ.2005. х-14